

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 05 сарын 13

Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Гэрэлтүүлэг тавих /19 дүгээр хороо/” ажил

Тендер шалгаруулалтын дугаар: **ЧДХААА ОНХС А20/21**

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Гэрэлтүүлэг тавих /19 дүгээр хороо/” ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн материалыг цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50 000 /тавин мянга/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- **Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих, түүний тоног төхөөрөмжийг хүргэх, суурилуулах ажлын нийт мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлтийг нь тооцох жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын борлуулалтын орлогын дундаж нь 29 500 000 /хорин есөн сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй байна.
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 17 700 000 /арван долоон сая долоон зуун мянга/ төгрөгөөс багагүй байна.
- **Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд 29 500 000 /хорин есөн сая таван зуун мянга/ төгрөгөөс багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

1. Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

Эрчим хүчний яамнаас олгодог:

- ✓ 03.9.3 0,4-110кв-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах.

Эсхүл: Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:

- ✓ 3Т-3.6 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн ажлын зураг эсхүл
- ✓ 1.3.3 Цахилгаан дамжуулах гол шугам сүлжээ түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг.

2. Ажил гүйцэтгэх байгууллага нь:

Эрчим хүчний яамнаас олгодог:

- ✓ 03.2.1 Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 0.4-10кВ ба болон түүнээс дээш заалт бүхий тусгай зөвшөөрөлтэй байх

Эсхүл: Барилга хот байгуулалтын яамнаас олгодог:

- ✓ БА-3.5 Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт эсхүл
- ✓ 2.2.8 Цахилгаан эрчим хүч дамжуулах гол магистраль шугам 35кв хүртэл угсралт.

Тендерийг **2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 10 цаг 00** минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 10 цаг 15** минутанд нээнэ.

Гадаадын этгээд:**Оролцох эрхгүй.**

Дотоодын давуу эрхийн зөрүү: **Тооцно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, IV хороо Ж.Самбуугийн гудамж-16, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр. Худалдан авах ажиллагааны алба,
5 дугаар давхар, 511 тоот өрөө Утас : 70110769